



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 2,827,845,719.00 (хоёр тэрбум найман зуун хорин долоон сая найман зуун дөчин таван мянга долоон зуун арван есөн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагад хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нар, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, хүлээлцэх ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.




ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
475 дугаар тогтоолын хавсралт



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН
ХӨРӨНГИЙН ДАНСАНД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо шир хэг	Нийт дүн (төгрөг)
Нэг. Тээврийн цагдаагийн алба					
1	Конторын барилга /БГД-ын ЗЦХэлтэс/	ширхэг	972,037,704.00	1	972,037,704.00
2	Гадна зам талбай /298 м2/	иж бүрдэл	113,546,351.00	1	113,546,351.00
3	Дээвэр /314 м2/	ширхэг	44,165,664.00	1	44,165,664.00
	Дүн			3	1,129,749,719.00
Хоёр. Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар					
1	ЦГ-ын конторын барилга	ширхэг	1,523,075,697.00	1	1,523,075,697.00
2	Гадна зам талбай /900 м2, хашаа 255 м/	иж бүрдэл	71,486,252.00	1	71,486,252.00
3	Гадна дулаан, цэвэр бохир усны шугам	иж бүрдэл	46,472,000.00	1	46,472,000.00
4	Дээвэр /440м2/	ширхэг	48,652,411.00	1	48,652,411.00
5	Гадна цахилгаан /0.4кв/	иж бүрдэл	8,409,640.00	1	8,409,640.00
	Дүн			5	1,698,096,000.00
	Нийт дүн				2,827,845,719.00 (хоёр тэрбум найман зуун хорин долоон сая найман зуун дөчин таван мянга долоон зуун арван есөн)